



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15100 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
О. Дамбалын гудамж 5/1, Засгийн газрын 1 байр,
Утасныг: (976-01) 20 74 05, И-мэйл: info@mol.gov.mn
Вэйбсайт: www.mol.gov.mn

2020.09.27 № 6-1/1992

танил _____-ий № _____-т

Гүйцэтгэгч сонгох ажиллагааг
түр түдгэлзүүлэх тухай

Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газраас зарласан БСШУСЯ/202001240 дугаартай "Сургуулийн барилга, 240 суудал /Ховд, Ховд сум"-ын тендер шалгаруулалтад оролцсон "Хатан түнгэл" ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт звасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан "Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам"-ын 4.6 дахь заалтад тус тус үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна. Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2020 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Захиалагчийн үнэлгээний хороо томилсон шийдвэр;
3. Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээний хуулбар;
4. Захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг;
5. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер /цахим тендер бол холбогдох файл/;
6. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
7. Үнэлгээний хорооны тайлан, хурлын тэмдэглэл;
8. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
9. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй тухай мэдэгдлийг оролцогч нэрт хургуулсан талаар нотлох баримт;
10. Захиалагч хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт звасны гомдол барагдуулах ажиллагаа явуулсан бол холбогдох мэдэгдэл, хурлын тэмдэглэл;
11. Холбогдох бусад баримт бичиг.


Гэрээ байгуулах эрх олгосон оролцогчид гомдол гарсан талаар мэдэгдэх, Захиргааны ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.15 дахь хэсэгт звасны дагуу гомдлыг хянах хугацаанд тендер шалгаруулалтын хүчинтэй байх хугацаа түр хугацаагаар зогсох болохыг үүгээр мэдэгдэж байна.

9761 09657

Түүнчлэн Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан "Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам"-ын 4.6-д звасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байх арга хэмжээ авна уу.

Хувийг: Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газарт.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ